

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАХУЙН ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ АСУУДАЛД

Л.Одгэрэл¹, Д.Солонго², Fiona Nolan³, Б.Оюунгоо⁴, З.Хишигсүрэн⁵

^{1,2,4} Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Сувилахуйн Сургууль,

⁵ Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Анагаах Ухааны Сургууль

³Anglia Ruskin University

Имэйл хаяг: odgerel.l@mnumns.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Б.Мэндхүү

Үндэслэл

Судлаач Dias JM, Ajani K. (2010) нар төгсөлтийн дараах сургалтын гол зорилго нь сувилахуйн гардан ур чадвар, асуудлыг тодорхойлж сэтгэн бодох шийдвэр гаргах, багаар ажиллах ур чадварыг дээшлүүлдэг болохыг тодорхойлжээ.³

Hickley M.T, Forbes M. нар судалгаандаа (2010) сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад сургалтын хөтөлбөрт агуулгын шинэчлэлт хийх хэрэгтэйг хөндсөн байна.⁴

Төгсөлтийн дараах сургалтын үр дүнд суралцагчдын чадвар, сургалтын үнэлгээ, сургалтын орчин чухал байдаг^{1,7}. Тухайн улс үндэстэн, ард иргэдийн эрүүл мэнд сайн сайхан байх нь анагаах ухааны боловсролын гол зорилго юм. Сургалтын хөтөлбөрийн жигд байдлыг хангахгүй, суралцагчдад чиглэсэн сургалтын үйл ажиллагааг доголдуулах нь нийгмийн хариуцлагыг алдагдуулж байдгийг дурьджээ.⁵

Монгол улсад сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр мэргэшсэн нийт 202 сувилагчаас одоо ажиллаж байгаа 170 (УБ хотод 110, орон нутгийн 60) сувилагч байна. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтийг АШУУИС-ийн Сувилахуйн сургууль, Дархан-Уул аймаг дахь салбар сургууль 3 сар, СЭМҮТ-д 4 сарын хугацаанд мэргэшүүлэн бэлтгэдэг.^{6,7}

ЭМЯ-наас (2010) сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээрх төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд сувилагч бэлтгэдэг сургуулиудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн хөтөлбөрийн нэршил, агуулга харилцан адилгүй, сургалтын орчин, сургалтын арга барил нь орчин үеийн хандлагын жишгээр боловсронгуй болж хөгжөөгүй, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн үндсэн багш хангалтгүй, ном сурах бичиг хомс, бие даан сургалт явуулах сургалтын орчин бүрдээгүй байжээ.⁸ Түүнээс хойш манай улсын анагаахын сургуулиудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтын чиглэлээр хийгдсэн ямар нэг судалгаа үгүй байна. Иймд бид энэ удаа сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн

сувилагчдын төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээг тодорхойлох шаардлагатай гэж үзэн, энэхүү судалгааг хийхээр зорилоо.

Зорилго

Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн сувилагч нарын төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээг тодорхойлоход оршино.

Зорилт

1. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтанд үнэлгээ хийх
2. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлох.

Түлхүүр үг: мэргэшил, хөтөлбөр, сургалт, үнэлгээ, сувилагч.

Арга аргачлал

Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдын төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээг зорилтын хүрээнд мэдээ мэдээлэл цуглуулахдаа дискретив судалгааны загвар, холимог судалгааны аргыг (mixed method) аргыг ашиглав. Судалгаанд Монгол улсад одоо ажиллаж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн нийт 144 сувилагчийг хамруулсан. (СЭМҮТ-85, Наркологийн төв эмнэлэг-7, УБ хотын 6 дүүргийн ӨЭМТ-ийн сэтгэцийн кабинетийн-6, 19 аймгийн сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч-46) Сэтгэцийн мэргэшсэн сувилагчдын төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээг тодорхойлох 37 өгөгдөл бүхий өөрсдийн боловсруулсан үнэлгээний хуудсыг ашигласан бөгөөд 10 сувилагчаас Pilot судалгаа авч асуумжийн найдвартай байдлыг Cronbach-ийн α коэффициентээр (0.78) тодорхойлов. ТДС-ийн хэрэгцээг тодорхойлох 37 өгөгдөл бүхий өөрсдийн боловсруулсан үнэлгээний хуудас. (хаалттай 11, хагас хаалттай-16) ашигласан бөгөөд 10 сувилагчаас Pilot судалгааг авч асуумжийн үнэн зөв байдлыг Cronbach-ийн α коэффициентээр задлан шинжилэхэд 0,78 байсан. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг 2020 оны 06 сарын 12-ны

өдрийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авч судалгааг 2020 оны 06-р сарын 20-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын хооронд хийв. Судалгааны үр дүнг SPSS-24 программ ашиглан, бүлгүүдийн хоорондын ялгаа, хамаарлыг статистикийн хувьд үнэн магадтай эсэхийг шалгасан болно.

Үр дүн

Судалгаанд сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн 144 сувилагч хамрагдсанаас 11.8% (17) нь эрэгтэй, 88.2% (127) нь эмэгтэй, дундаж нас 39.3 ± 9.4 байлаа. Сувилагчдын улсад ажилласан жил 15.2 ± 10.3 , сэтгэцийн чиглэлээр ажилласан жил 8.4 ± 9.3 байна. Боловсролын хувьд магистр 3% нь, 39% нь дипломын магистр бөгөөд мэргэжлийн зэргийн хувьд тэргүүлэх 5.6% нь тэргүүлэх, 20.9% нь ахлах зэрэгтэй байна.

Хүснэгт 1. Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байдал

№	Сургуулийн нэр	N	%
1	АШУҮИС	22	15.3
2	СЭМҮТ	122	84.7

Монгол улсын хэмжээнд АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль, СЭМҮТ зэрэг байгууллагууд Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтаар “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч”-ийг бэлтгэж байгаа бөгөөд бидний судалгаанд хамрагдсан сувилагчдын 15.7% нь АШУҮИС, Сувилахуйн сургууль, 87.3% нь СЭМҮТ-ийн сургалтанд хамрагдсан байна.

Зураг 1. Мэргэшсэн сувилагчдын давтан сургалтанд хамрагдсан байдал



Мэргэшүүлэх сургалтанд хамрагдснаас хойш сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр давтан сургалтанд хамрагдсан байдлаас харахад 92% нь энэ чиглэлээр сургалтанд хамрагдаагүй, 8% нь байгууллага дээрээ багц цагийн сургалтанд хамрагдсан байна.


Судалгаанд хамрагдсан сувилагчдын (7) 4.9% нь 45 хоногийн курст суралцсан болох нь статистик ач холбогдолтой ($p=0.017$) байна. (Хүснэгт 2) Суралцагчдын дийлэнх нь буюу 68% (98) нь 3 сараар, 41.3% (39) нь 4 сараар тус тус суралцсан байна.

Хүснэгт 2. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдын төгсөлтийн дараах сургалтанд хамрагдсан байдал (хугацаагаар)

Сургалтын хугацаа	АШУҮИС, Сувилахуйн сургууль	СЭМҮТ	Бүгд	P – утга
45 хоногийн курс	2 (9.1)	5 (4.10)	7 (4.86)	0.017
3 сарын курс	20 (90.9)	78 (63.93)	98 (68.05)	0.000
4 сарын курс	0 (0.0)	39 (31.96)	39 (27.08)	0.000


Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийг бэлтгэх төгсөлтийн дараах сургалтын хугацааны хувьд нийт төгсөгчдийн 47% (69) нь хангалтгүй, 53% (75) нь суралцах хугацаа хангалттай, сэтгэл ханамжтай гэж хариулсан байна.

Зураг 2. Төгсөлтийн дараах сургалтын хугацааны сэтгэл ханамж




Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдаас төгсөлтийн дараах сургалтын хугацааг цаашид ямар хугацаагаар бэлтгэх нь тохиромжтой эсэхийг асуумж судлагаагаар тодруулахад 37.5% (54) нь хугацааг сунгах шаардлагагүй буюу 3 сар байх нь хангалттай гэж үзсэн бол 6.9% (9) нь 4 сар, 43.1% (62) нь 6 сар, 12.5% (18) нь 9 сар байх нь тохиромжтой гэж хариулжээ.

Зураг 3. Төгсөлтийн дараах сургалтын хугацааны талаарх санал (хувиар)




Судалгаанд хамрагдагсдаас сургалтын орчин хэр зэрэг байгааг үнэлж үзэхэд: 61.8% нь орчин тохилог, 30.6% нь дунд зэрэг, 7.6% нь орчны тав тух хангалтгүй гэж үнэлсэн байна.

Зураг 4. Сургалтын орчны талаарх үнэлгээ




Төгсөлтийн дараах сургалтын ном, сурах бичгийн хүрэлцээний байдлыг судлахад 47.2% нь ном сурах бичиг хүрэлцээтэй, 41.3% нь дунд зэрэг, 8.7% нь хүрэлцээ муутай гэсэн байна.

Зураг 5. Ном, сурах бичгийн хүрэлцээ



Судалгаанд хамрагдагсдын сувилахуйн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн байдлыг судлахад 34.7% нь илтгэл судалгааны ажил бичиж хэвлүүлсэн, 65.3% нь судалгааны ажил хийгээгүй байгаа нь мэргэшсэн сувилагч нарыг эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хөгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зураг 6. СЭМ-ийн мэргэшсэн сувилагчийн онол, дадлагын хичээлийн уялдаа



Хүснэгт 3. СЭМ-ийн мэргэшсэн сувилагчдын өөртөө итгэлтэй байдал

Хамаарал	Өөртөө итгэлтэй байдлын харьцуулсан оноо					
	Итгэлгүй (n=8)	Зарим (n=27)	Ерөнхийдөө (n=79)	Маш сайн (n=30)	Нийт (n=144)	P утга
	Дундаж ± СХ	Дундаж ±СХ	Дундаж ± СХ	Дундаж ± СХ	Дундаж ± СХ	
Нас	32.9 ± 3.1	37.1 ± 10.3	38.9 ± 9.0	44.4 ± 8.6	39.4 ± 9.3	0.000
Ажилласан жил /сэтгэц	1.3 ± 0.7	3.0 ± 1.5	3.4 ± 1.5	4.3 ± 1.4	3.4 ± 1.6	0.000
	N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)	
Хүйс	-	-	-	-	-	-
Эр	-	3 (11.1)	9 (11.4)	5 (16.7)	17 (11.8)	0.357
Эм	8 (100)	24 (88.9)	70 (88.6)	25 (83.3)	127 (88.2)	

Хүснэгт 3-аас харахад сэтгэцийн мэргэшсэн сувилагчдын ажилласан жил, нас нь бага байх тусам өөртөө итгэлтэй байдлын оноо буурч статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. $P < 0.000$

Хэлцэмж

Австралийн төгсөлтийн дараах (PG) сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтын мэргэшсэн сувилагчдын мэдлэг, чадварыг судлах зорилготой хийгдсэн чанарын судалгаанд сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн мэдлэг, чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах сувилахуйн судалгааг хөгжүүлэх, сайжруулах нь тулгамдсан асуудал болж байна¹¹ гэсэн нь бидний судалгаанд хамрагдсан сувилагчдын 65.3% нь төгсөлтийн дараах сургалтаас хойш ямар нэгэн судалгааны ажил хийгээгүй, илтгэл өгүүлэл бичээгүй байгаа нь мэргэшсэн сувилагч нарыг энэ чиглэлээр хөгжүүлэх шаардлагатай байлаа гэсэн үр дүнтэй дүйцэж байна.

АНУ-ын сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн нийгэмлэгээс (2013) сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагч нарын дунд хийсэн судалгааны үр дүнд ажлын байрны болон суралцах орчинг бүрдүүлэх, мэргэшсэн сувилагчийг хөгжүүлэх шаардлагатай¹² гэж 58% нь хариулсан байна. Харин бидний судалгаанд сургалтын орчинг 30.6% нь дунд зэрэг, 7.6% нь хангалтгүй гэсэн нь цаашид сургалтын орчинг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Ickley M.T, Forbes M. нар судалгаандаа (2010) сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад сургалтын хөтөлбөрт агуулгын шинэчлэлт хийх хэрэгтэйг хөндсөн байна¹³. Бид судалгаандаа мэргэшсэн сувилагч нар сургалтын онол, дадлагын хичээл хоорондын уялдаа холбоог (78) 54.2% нь хангалттай, (53) 36.8% дунд зэрэг (13) 9% нь хангалтгүй гэж үнэлсэн нь манай орны сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшсэн сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх хэрэгцээтэй байгаатай ойролцоо байлаа.

ЭМЯ-аас 2011 онд Анагаахын чиглэлээр сургалт явуулдаг сургуулиудын “Сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөр, стандартын өнөөгийн байдал”-ыг судалсан судалгаанд нийт судалгаанд оролцогчдын 74% нь энэхүү сургалтын ном сурах бичиг, гарын авлага хангалтгүй байдаг¹⁴ гэсэн судалгааны дүн бидний судалгаанд 41.3% нь дунд зэрэг, 8.7% нь хангалтгүй гэсэнтэй дүйцэж байна.

Дүгнэлт

1. Бидний судалгаанаас харахад Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх мэргэшүүлэх сургалтын хугацаа нь өнөөгийн эрэлт хэрэгцээг хангахгүй, цаашид хугацааг нэмэгдүүлэх, сургалтын орчин нөхцлийг сайжруулах, ном сурах бичгээр хангах, хичээлийн онол, дадлагын уялдааг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдлаа.
2. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хэрэгцээг үнэлэхэд эмч багш, сувилагч багш нарын заах ур чадвар сайн, харин дийлэнх сувилагчид ямар нэгэн судалгааны ажил хийдэггүй нь судалгааны аргазүйн хичээл дутагдалтай, цаашид хөтөлбөрт энэ талаар тусгаж шинэчлэх шаардлагатай, одоо ажиллаж буй сувилагчдын ажилласан жил бага, нас нь залуу байх тусам өөртөө итгэлтэй байдал буурч байгаа ($P < 0.000$) нь анхаарал татаж байлаа.